



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 1/94

Улаанбаатар хот

Улаанбаатар хотын шуурхай
удирдлага, зохицуулалтын төв
ОНӨААТҮГ-ын балансаас хөрөнгө
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 15,675,000 (арван таван сая зургаан зуун далан таван мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Нийслэлийн Онцгой байдлын газрын балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Улаанбаатар хотын шуурхай удирдлага, зохицуулалтын төв ОНӨААТҮГ (Ч.Ган-Очир)-т зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж авахыг Нийслэлийн Онцгой байдлын газар (А.Дашням)-т үүрэг болгосугай.

3.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Улаанбаатар хотын шуурхай удирдлага, зохицуулалтын төв ОНӨААТҮГ (Ч.Ган-Очир)-т, Нийслэлийн Онцгой байдлын газар (А.Дашням)-т тус тус үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050000337